



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2024 оны 01 сарын 04-ны  
өдрийн 6532 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 11259

Улаанбаатар хот

Тендер шалгаруулалтын жишиг  
баримт бичиг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.14, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” Сангийн сайдын 2021 оны 145 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд нийцүүлэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш зарлах нээлттэй тендер шалгаруулалтад дагаж мөрдсүгэй.

Б.ЖАВХЛАН

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ  
ХУУЛБАР ҮНЭН  
Бүртгэлийн № 211  
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга  
Архивын гэхлэгч  
Хуудас 48  
2023 оны 12 сарын 28 өдөр

9763000846